

БҮРЭН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ИХ ЗАСВАР

/Төндерийн баримт бичиг/

ТӨСЛИЙН НЭР:

БҮРЭН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ИХ ЗАСВАР

БАЯНТӨХӨМ

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ:**

1. Барилын засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.
2. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зориулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчиний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.
3. Үнийн саналд барилгын засварын ажлын тооцоог Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12*2020-г тооцож ирлүүлнэ.
4. Үнийн тарифыг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.
5. Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖИЛ

1.Үзэгчдийн суудлын шалны ажил

Урлаг заалны түвшний үзэгчдийн суух хэсгийг бүрэн буулгаж засварлах, Барилгын газар широоны ажлыг гүйцэтгэхдээ БНБД 50-02-17-г баримтална. Бетон цутгалтын ажлыг гүйцэтгэхдээ “Цутгамал бетон, төмөр бетон бүтээц”-ийн угсралтын БНБД 52-02-05, Цутгамал төмөр бетоны ажил гүйцэтгэх заавар БД52-102- 04-ийн холбогдох заалтуудын дагуу гүйцэтгэнэ. Одоо байгаа шалны эвдэрч муудсан модон шалыг хуулж авч 100-150 см зузаан дайрга хийж нягтаршуулан, уур ус тусгаарлагч хийх, XSP см зузаантай хөөсөн хавтангаар дуулаалга хийх, 100-150 мм зузаан бетон цутгаж прикатан шал хийх

2.Үзэгчдийн сандал

Сайн чанарын материалыар хийгдсэн эдэлгээ даах, 50 ширхэг сандал

3.Хаалга, цонхны ажил

Цонхны дулаан алдалтыг багасахын тулд хөөсөн дулаалга хийх, Бүх хаалгыг шинээр солих, Зарим өрөө тасалгаанд шинээр хаалга гаргах мөн хуучин 5 ширхэг хаалгыг буулгаж ханыг битүүлэн өрөх. Барилгад цонх, хаалга нь MNS-6266:2011, MNS-5830:2007 стандарт дулаан техникийн шаардлага хангасан байвал зохино.

4.Дотор заслын ажил

Одоо байгаа ханын халцарч муудсан өнгөлгөөг сайтар хусаж арилган тэгшилгээ хийж зургийн дагуу ханыг сайн чанарын өнгөлгөө хийнэ. Заслалын ажилд хэрэглэх материалыуд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна. Танхимиын ханыг сайн чанарын акустик хавтангаар доторлоно. Таазанд замаска хийж эмульсээр будах

5.Гадна заслын ажил

Соёлын төв, Бүжгийн заалны гадаргууг шавардаж тэгшилгээ хийж цайвар шаргал өнгийн фасадны эмульс хийхээр төлөвлөсөн.

6.Хаяавч

Барилгын сууринд ус орохоос сэргийлж 500 мм-н өргөнтэй хаявчийг Б10 маркийн бетоноор барилгын периметрийн дагуу гүйцэтгэнэ. Хаявчийн зузаан 100 мм байна.

7. Явган хүний зам

Соёлын төвийн зүүн талын хаалганаас ЗДТГазрын зүүн талын боржуур хүртэл 1м20 см өргөнтэй 66 м замыг 30*30 харьцаатай хавтангаар хийх

8. Ариун Цэврийн өрөөний –ны ажил

Дотор хана ½ -ын тоосгоор өрж дотор тоосго бат бетон ханыг шохойн зуурмагаар гараар ердийн шавардах хананд замаскан тэгшилгээ хийж хана эмульсээр будах ханын плита нааж шалны плитан хавтанцар наах, Дээврийн эрдэс хөвөн ба базалт 15 см таазанд замаска хийх тааз эмульсээр будах, дотор хаалга угсралт ариун цэврийн өрөөний хаалт бэлэн өнгөлгөөтэй модон хийцээр хийж 2 ширхэг суултуур, 1 босоо 00, толь, гар хатаагч, угаалтуур -2 ширхэг суурилуулах

9. АГААР СЭЛГЭЛТИЙН СИСТЕМ ШИНЭЭР ХИЙХ АЖИЛ

Уг барилга нь одоогоор агаар сэлгэлтийн системгүй байгаа тул барилгын агаар сэлгэлтийн системийг шинээр хийх. Агаар сэлгэлтийг ердийн болон механик системээр төлөвлөв. Дээвэрт ил гарах агааржуулалтын шахт, яндан хоолой, бохирын хоолой зэргийг цан цохихоос хамгаалж дулаалтын материал ашиглаж дулаалж өгөх шаардлагатай.

10. ЦЭВЭР БОХИР УСНЫ АЖИЛ

Соёлын төвийн үүдний хэсгийг тохижуулан цэвэр бохир усны шугамд шинээр холбон ариун цэврийн өрөө бий болгох. Дотор цэвэр, бохир, усны системийн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 40-05-98-ийг мөрдлөг болгоно. Цэвэр хүйтэн усны шугамыг цайдсан ган болон хөнгөн цагаан голчтой хуванцар хоолойгоор, бохир утсыг 35 м хуванцар хоолойгоор дамжуулан бохир усны төвлөрсөн шугамд холбоно. Ариун цэврийн өрөөнөөс 5 мт бохирын худаг гаргана. Цэвэр усанд баталгаажсан стандартын шаардлага хангасан тоолуур тавина. Цэвэр усны шугам сүлжээний бөмбөлгөн хайлтууд болон холбох хэрэгсэл тоноглол зэргийг сайн чанарын материалыар хийж гүйцэтгэх ба ил явж байгаа цэвэр бохир усны шугам хоолойн бэхэлгээг сайн хийх шаардлагатай.

11. ДОТОР ГЭРЭЛТҮҮЛЭГИЙН АЖИЛ




Ариун цэврийн өрөөг цахилгаанд холбон гэрэл цахилгаантай болгох .

12. ДОТОР, ГАДНА ЦАХИЛГААНЫ АЖИЛ

Цахилгааны монтажны угсралтын ажлыг гүйцэтгэх үед БД43-101-03, БД 43- 102-07, БНБД – 81-20-04, БНБД – 81-30-04 –г мөрдлөг болгоно. -Дотор цахилгаан тоног төхөөрөмж, кабель утсыг сунгах, утас сүвлэх яндан хоолойг угсралт, шавардлагын доорх далд монтажийн утсыг татаж бэхлэх ажлыг угсралтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Цахилгааны ажлыг төсөвт тусгагдсан кабелиар барилгын норм дүрэм стандартын дагуу чанартай хийх шаардлагатай. Цахилгааны холболтын ажилд ПВ-3х4 мм², ПВ-2x2.5 мм² маркийн зэс голтой утас хэрэглэнэ. Барилгын дотор сүлжээг TN-S /5-утаст: нойлийн (N) ба хамгаалалтын нойлийн (PE) дамжуулагчууд нь бүх системд тусдаа 3фаз+N+PE/ системээр гүйцэтгэнэ. Унтраалга, разетка нь ус чийгнээс хамгаалагдсан байна.

**ТӨВ АЙМАГ, БҮРЭН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛД
ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ**

Техник хэрэгслийн үнэ

Д/ Д	Нэр төрөл	Үзүүлэл т	Зураг	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сандал			50	180000	9,000,000
2	Угаалтуур			2	250000	500000
3	Суултуур			2	300000	600000
4	Босоо ОО			1	150000	150000
5	Гар хатаагч			1	150000	150000
Нийт өртөг				106		19,400,000

АЖЛЫН АЛБАН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:
БҮЖГИЙН БАГШ *Д.Солонго*